МЭДЭЭ · 2025 оны 4-р сарын 3

СУМДАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХАД АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА



Сэлэнгэ аймгийн Сайхан сум дундын прокурорын газраас хяналтын харьяа Сайхан, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын хэмжээнд үйлдэгдсэн зөрчлийн гаралт, шийдвэрлэлтийг судалжээ. Судалгаагаар тус сумдын хэмжээнд 2024 онд 911 зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авсан нь өмнөх жилээс 12.4 хувиар өссөн байна.

2025 оны 3 дугаар сарын байдлаар нийт 167 зөрчил бүртгэгдсэнээс замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 63.4 хувийг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил 11.3 хувийг эзэлж байна.

Сайхан сум дахь сум дундын прокурорын газраас хяналтын харьяа байгууллагуудын зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудтай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад учирч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцжээ.

Мөн эрх бүхий албан тушаалтнаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах, хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга бат, хариуцлагыг чандлан сахиж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, шинээр батлагдан гарч буй хууль тогтоомжийн талаар сургалт, яриа таниулгыг тогтмол зохион байгуулж ажиллахаар ярилцсан байна.

Зөвлөгөөнд Сэлэнгэ аймгийн Сайхан сумын засаг дарга, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дарга болон дээрх сумдын 40 гаруй алба хаагч оролцжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/724